АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Архангай аймгийн Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2025/36-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br><br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор Б.Азантунгалаг<br>Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.24 № 51

танай ______________-ны №______________-т

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЧИР-ЭРДЭНЭ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож, албан татварыг суутгаагүй нийт 4,976.9 мянган төгрөгийг илүү олгосон;
2. Мал төхөөрөх цехийн ажил гүйцэтгэх гэрээг сумын Засаг даргын 2024 оны А/77 тоот захирамжаар байгуулан 139,669.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосны ажил гүйцэтгэснийг нотлох анхан шатны баримтгүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд 960,528.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 919,034.5 мянган

төгрөгийг зарцуулж, 41,494.3 мянган төгрөгийн төсвийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 8 зорилт 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 118 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 9 арга хэмжээ 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 83.9 хувьтай үнэлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,735,950.10 | 41,548,650.10 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8,835,950.10 | 15,868,650.10 |
| 354 | Хангамжийн материал | 6,720,950.10 | 13,753,650.10 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 490,950.00 | 3,585,950.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 5,980,000.10 | 7,934,200.10 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 250,000.00 | 2,233,500.00 |
| 355 | Биологийн хөрөнгө | 2,115,000.00 | 2,115,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 20,900,000.00 | 25,680,000.00 |
| 363 | Тэжээлийн нөөц | 11,000,000.00 | 25,680,000.00 |
| 366 | Бусад нөөц | 9,900,000.00 | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,082,272,987.50 | 2,765,378,218.18 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,082,272,987.50 | 2,765,378,218.18 |
| 392 | Биет хөрөнгө | 2,070,290,987.50 | 2,752,515,218.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,084,876,517.50 | 2,284,876,517.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -558,888,378.15 | -639,278,947.15 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 234,261,500.00 | 384,584,792.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -89,053,749.84 | -112,681,497.67 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 64,434,465.00 | 91,724,465.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -32,465,535.70 | -41,589,870.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,023,680.00 | 23,223,680.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -2,195,906.99 | -7,206,827.15 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 448,465,630.16 | 740,705,130.16 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -101,287,814.48 | -141,632,752.29 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | 169,669,948.00 |
| 39217 | Ном | 120,580.00 | 120,580.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 11,982,000.00 | 12,863,000.00 |
| 39301 | Програм хангамж | 750,000.00 | 750,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -375,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 11,532,000.00 | 12,488,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,112,008,937.60 | 2,806,926,868.28 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 1,858,994.60 | 521,400.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,858,994.60 | 521,400.00 |
| 413 | Өглөг | 1,858,994.60 | 521,400.00 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,858,994.60 | 521,400.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,110,149,943.00 | 2,806,405,468.28 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,110,149,943.00 | 2,806,405,468.28 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 430,807,876.17 | 430,807,876.17 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |

| | | | |
|---|---|---|---|
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 51101 | Өмч: - төрийн | 430,807,876.17 | 430,807,876.17 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 957,352,643.86 | 1,653,608,169.14 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 957,352,643.86 | 957,352,643.86 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 696,255,525.28 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 721,989,422.97 | 721,989,422.97 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,112,008,937.60 | 2,806,926,868.28 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 938,762,659.16 | 1,897,504,472.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 353,814,929.16 | 762,161,069.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 353,814,929.16 | 762,161,069.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 331,097,929.16 | 698,091,292.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,900,000.00 | 55,714,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 584,947,730.00 | 1,135,343,403.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,375,130.00 | 174,914,603.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 2,050,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,375,130.00 | 141,645,853.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 18,218,750.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 582,572,600.00 | 960,428,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 582,572,600.00 | 960,428,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 716,353,322.35 | 1,201,248,946.72 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 690,753,322.35 | 1,201,248,946.72 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 671,441,679.24 | 1,102,879,087.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 382,550,993.64 | 585,374,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 289,785,218.92 | 386,382,321.45 |
| 210102 | Нэмэгдэл | 85,925,874.72 | 198,992,578.55 |
| 210104 | Урамшуулал | 6,839,900.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 47,834,500.00 | 74,826,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,527,400.00 | 50,024,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,826,800.00 | 5,885,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,061,400.00 | 4,707,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 765,400.00 | 2,439,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,653,500.00 | 11,769,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,342,063.15 | 47,580,675.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,493,567.73 | 9,717,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 37,662,795.42 | 37,841,975.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 185,700.00 | 20,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 37,758,394.60 | 108,107,550.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,362,400.00 | 2,982,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,966,200.00 | 31,380,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,982,994.60 | 7,781,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 645,000.00 | 320,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,386,410.00 | 13,985,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,415,390.00 | 51,338,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 320,000.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,046,000.00 | 21,717,505.40 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 1,717,505.40 |
| 210604 | Урсгал засвар | 5,046,000.00 | 20,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,000,000.00 | 4,518,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,000,000.00 | 4,518,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,573,930.00 | 25,607,747.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,453,930.00 | 21,067,747.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,100,000.00 | 4,500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 20,000.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 144,335,797.85 | 235,146,009.32 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,325,800.00 | 59,512,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 3,000,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 126,009,997.85 | 172,633,509.32 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,311,643.11 | 98,369,859.48 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,352,100.00 | 48,619,938.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 46,619,938.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,352,100.00 | 2,000,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,959,543.11 | 49,749,921.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,959,543.11 | 49,749,921.48 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 25,600,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 25,600,000.00 | |
| 221001 | Их засвар | 25,600,000.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 222,409,336.81 | 696,255,525.28 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 222,409,336.81 | 696,255,525.28 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 587,264,730.00 | 1,143,698,980.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,817,000.00 | 8,355,577.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 585,447,730.00 | 1,135,343,403.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,875,130.00 | 174,914,603.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 2,050,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 13,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,375,130.00 | 141,645,853.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 500,000.00 | 18,218,750.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 582,572,600.00 | 960,428,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 582,572,600.00 | 960,428,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 561,664,730.00 | 986,051,532.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 561,664,730.00 | 986,051,532.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 542,353,086.89 | 887,681,672.52 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 382,542,193.74 | 585,374,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 289,776,419.02 | 386,382,321.45 |
| 210102 | Нэмэгдэл | 85,925,874.72 | 198,992,578.55 |
| 210104 | Урамшуулал | 6,839,900.00 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 47,834,500.00 | 74,826,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,527,400.00 | 50,024,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,826,800.00 | 5,885,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,061,400.00 | 4,707,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 765,400.00 | 2,439,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,653,500.00 | 11,769,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,342,063.15 | 47,580,675.52 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,493,567.73 | 9,717,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 37,662,795.42 | 37,841,975.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 185,700.00 | 20,900.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,899,400.00 | 50,048,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,362,400.00 | 2,982,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,966,200.00 | 21,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,124,000.00 | 9,260,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 645,000.00 | 320,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 12,386,410.00 | 13,985,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,415,390.00 | 2,500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,046,000.00 | 22,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,046,000.00 | 20,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,000,000.00 | 4,518,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,000,000.00 | 4,518,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,688,930.00 | 28,702,747.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,568,930.00 | 24,162,747.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,100,000.00 | 4,500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 20,000.00 | 40,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,000,000.00 | 74,630,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,000,000.00 | 71,630,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 3,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 19,311,643.11 | 98,369,859.48 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,352,100.00 | 48,619,938.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 46,619,938.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,352,100.00 | 2,000,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,959,543.11 | 49,749,921.48 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,959,543.11 | 49,749,921.48 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 25,600,000.00 | 157,647,448.00 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 25,600,000.00 | 157,647,448.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 25,600,000.00 | 157,647,448.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 25,600,000.00 | 157,647,448.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -25,600,000.00 | -157,647,448.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 430,807,876.17 | 721,989,422.97 | 957,352,643.86 | 2,110,149,943.00 |
| 2 | Тайлант үеийн үр дүн | | | 696,255,525.28 | 696,255,525.28 |
| 3 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 430,807,876.17 | 721,989,422.97 | 1,653,608,169.14 | 2,806,405,468.28 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 960,528,800.00 | 919,034,455.52 | 41,494,344.48 | 96% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 960,528,800.00 | 919,034,455.52 | 41,494,344.48 | 96% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 878,476,400.00 | 870,414,517.52 | 8,061,882.48 | 99% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 585,374,900.00 | 585,374,900.00 | 0.00 | 100% |
| 210101 | Үндсэн цалин | 585,374,900.00 | 386,382,321.45 | 198,992,578.55 | 66% |
| 210102 | Нэмэгдэл | 0 | 198,992,578.55 | -198,992,578.55 | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 74,826,700.00 | 74,826,700.00 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,024,400.00 | 50,024,400.00 | 0.00 | 100% |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,885,000.00 | 5,885,000.00 | 0.00 | 100% |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,707,900.00 | 4,707,900.00 | 0.00 | 100% |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,439,500.00 | 2,439,500.00 | 0.00 | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,769,900.00 | 11,769,900.00 | 0.00 | 100% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 48,037,800.00 | 47,580,675.52 | 457,124.48 | 99% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,717,800.00 | 9,717,800.00 | 0.00 | 100% |
| 210302 | Түлш, халаалт | 37,920,000.00 | 37,841,975.52 | 78,024.48 | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 20,900.00 | 379,100.00 | 5% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 49,065,600.00 | 49,048,150.00 | 17,450.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 3,000,000.00 | 2,982,550.00 | 17,450.00 | 99% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,000,000.00 | 20,000,000.00 | 0.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 9,260,000.00 | 9,260,000.00 | 0.00 | 100% |
| 210404 | Ном, хэвлэл | 320,000.00 | 320,000.00 | 0.00 | 100% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 13,985,600.00 | 13,985,600.00 | 0.00 | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,500,000.00 | 2,500,000.00 | 0.00 | 100% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 32,500,000.00 | 30,500,000.00 | 2,000,000.00 | 94% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 12,500,000.00 | 10,500,000.00 | 2,000,000.00 | 84% |
| 210604 | Урсгал засвар | 20,000,000.00 | 20,000,000.00 | 0.00 | 100% |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,000,000.00 | 4,518,000.00 | 482,000.00 | 90% |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,000,000.00 | 4,518,000.00 | 482,000.00 | 90% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,671,400.00 | 20,566,092.00 | 5,105,308.00 | 80% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,731,400.00 | 16,026,092.00 | 4,705,308.00 | 77% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,900,000.00 | 4,500,000.00 | 400,000.00 | 92% |
| 210807 | Газрын төлбөр | 40,000.00 | 40,000.00 | 0.00 | 100% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 58,000,000.00 | 58,000,000.00 | 0.00 | 100% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,000,000.00 | 55,000,000.00 | 0.00 | 100% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 82,052,400.00 | 48,619,938.00 | 33,432,462.00 | 59% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 82,052,400.00 | 48,619,938.00 | 33,432,462.00 | 59% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,350,400.00 | 0 | 22,350,400.00 | 0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 57,702,000.00 | 46,619,938.00 | 11,082,062.00 | 81% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100% |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 960,528,800.00 | 919,034,455.52 | 41,494,344.48 | 96% |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 861,928,800.00 | 910,678,878.52 | -48,750,078.52 | 106% |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 861,928,800.00 | 910,678,878.52 | -48,750,078.52 | 106% |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 98,600,000.00 | 8,355,577.00 | 90,244,423.00 | 8% |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 100,000.00 | 8,355,577.00 | -8,255,577.00 | 8356% |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 98,500,000.00 | 0 | 98,500,000.00 | 0% |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 51 | 51 | 0.00 | 100% |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25 | 25 | 0.00 | 100% |
| 620001 | Удирдах ажилтан | 7 | 7 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | 0.00 | 100% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | 0.00 | 100% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 25 | 25 | 0.00 | 100% |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 9 | 0.00 | 100% |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 | 0.00 | 100% |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6 | 6 | 0.00 | 100% |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **174,914,603** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **35,244,655** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 35,244,655 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,336,655 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,336,655 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,908,000 |

| | | |
|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,908,000 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **139,669,948** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 139,669,948 |
| 223001 | Бусад хөрөнгө | 139,669,948 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 174,914,603 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 174,914,603 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,050,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 141,645,853 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,218,750 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 30,000.0 мянган төгрөгийн 1 алдаа[1] илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Тайлант онд сумын ОНХС-ын хөрөнгөөр баригдсан 30,000,000 төгрөгийн мал төхөөрөх цехийг зөрүүтэй тусгасныг аудитын явцад залрууллаа.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1,15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 195,358.8 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч 4,967.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 190,390.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 140,191.3 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 10,805.9 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг олгохдоо , ХХОАТ-ыг суутгаж татварт төвлөрүүлээгүй, нийт 4,967,976.8 төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-д "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>:*** *Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.*

### 5.2 Албан шаардлага

5.2.1. Тайлант онд шуудан холбооны зардлын 521,400 төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

***Шийдвэрлэсэн нь***: *Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.*

5.2.2. Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 7 нэр төрлийн 50,199,640 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь***: *Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журамыг баримтлан холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.*

5.2.3. Тендерийн АРАӨСЗДТГ/20240201010 дугаартай Мал төхөөрөх цехийн ажил гүйцэтгэх гэрээг сумын Засаг даргын 2024 оны 07 сарын 26-ны өдрийн А/77 тоот захирамжаар байгуулан, 2024 оны 12 сарын 26-ны өдрийн А/122 тоот захирамжаар 139,669,948 төгрөгийн санхүүжилт олгохдоо ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хэрэгжүүлээгүй, ажил гүйцэтгэсэн эсэхийг нотлох анхан шатны баримтгүйгээр санхүүжилт олгосон зөрчил  илэрлээ.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт, тайлагнах журам”-ын  5.3.6-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна”, 5.3.7-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээд нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн баримт бичгийн хамт захиалагчийн архивд хадгалуулна”  гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь***: *Төсөл арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журамд заасны дагуу олгох, арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.*

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдаа ны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| НББ-д буруу илэрхийлсэн | 1 | 30,000 | | | 1 | 30,000 | 1 | 30,000 | | | - | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөдөө орон нутагт суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллаас 7 албан хаагчид нийт 4,967.9 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 4,967.9 | 1 | 4,967.9 | | |
| Тайлант онд шуудан холбооны зардлын 521.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна | 1 | 521.4 | | | 1 | 521.4 |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 7 нэр төрлийн 50,199.6 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. | 1 | 50,199.6 | | | 1 | 50,199.6 |
| АРАӨСЗДТГ/20240201010 гэрээний дугаартай Мал төхөөрөх цехийн ажил гүйцэтгэх гэрээг сумын Засаг даргын 2024 оны 07 сарын 26-ны өдрийн А/77 тоот захирамжаар эрх олгосны дагуу байгуулан, 2024 оны 12 сарын 26-ны өдрийн А/122 тоот захирамжаар 139,669,948 төгрөгийн санхүүжилт олгосон байна. Санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хэрэгжүүлээгүй, ажил гүйцэтгэсэн эсэхийг нотлох анхан шатны баримтгүйгээр санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ. | 1 | 139,669.9 | | | 1 | 139,669.9 |
| **Нийт дүн** | **4** | **195,358.8** | **1** | **4,967.9** | **3** | **190,390.9** |